

ЗӨВЛӨМЖ

(“Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай”
Монгол Улсын Сайд, ЗГХЭГ-ын даргын
2018.06.18-ны өдрийн ХЭГ/1383 албан
бичгийн хүрээнд)

2018.07.03

Үндэслэл:

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 5.1.3, 5.2.3-ын заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай” Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны ХЭГ/1383 албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн алдаа оноо, бодит үр дүн, үнэтэй сургамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хэвшүүлэхийг аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтэс (ТЗУХ, ХЭЗХ, ХОХБТХ, НБХ, СТСХ)-үүдэд зөвлөж байна.

Эрх зүйн баримт бичиг:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /УИХ-ын 2016 оны 19-р тогтоол/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /2015.11.26/
- Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”
- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /УИХ-ын 2016 оны 45-р тогтоол/
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /ЗГ-ын 2016 оны 121-р тогтоол/
- “Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай” Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны ХЭГ/1383 албан бичиг
- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /Дархан-Уул аймгийн ИТХ-ын ээлжит бус Гуравдугаар хуралдааны 2016 оны 3/03-р тогтоол/

- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны А/477 дугаар захирамж/

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь “Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ”-г Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу дараах 11 баримт бичгүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Үзүүлэлтүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг нэг бүрчлэн үзүүлбэл:

№	Үзүүлэлт	ЗГХЭГ-ын үнэлгээ	ЗДТГ-ын өөрийн үнэлгээ	Зөрүү
1.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	92.0	98.32	-6.32
2.	Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	69.0	96.1	-27.1
3.	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	91.5	98.4	-6.9
4.	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	89.2	95.7	-6.5
5.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	93.2	97.2	-4.0
6.	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	89.3	100	-10.7
7.	Шилэн дансны хөтлөлт	93.9	98.8	-4.9
8.	Шударга байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа ¹	69.8	-	-
9.	Засгийн газрын гишүүнээс аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	94.4	98.4	-4.0
10.	Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын үнэлгээ	76.0	100	-24.0
11.	Хэрэглэгчийн үнэлгээний тайлан	60.1	50.9 ²	+9.2
Ерөнхий үнэлгээ		85.6	98.0	-12.4

¹ Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн дагуу АТГ-ын даргын 2010 оны 59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлж дүгнэдэг. 2017 онд судалгааг шинжээч, төрийн албан хаагчид, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон иргэд зэрэг нийт 70 хүнээс судалгаа авсан болно.

² Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 9.7, 9.8 дахь заалтыг үндэслэн хэрэглэгчийн үнэлгээ буюу сэтгэл ханамжийн судалгааг ЗГХЭГазар, Дэлхийн банкны зөвлөхтэй хамтран **туршилтын судалгааг** Дархан-Уул аймагт 2017 оны 12 дугаар сард хийж, судалгааны тайлан болон тайлангийн дүн шинжилгээг ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т 2018.02.12-ны өдрийн 1-10/103 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

Монгол Улсын хэмжээнд нийт 22 (аймаг, нийслэл) байгууллагаас: хамгийн өндөр оноо 88.3%, хамгийн бага оноо 78.5%-иар үнэлэгдэж, эрэмбэлэгдсэн байна. Үүнээс 4 аймаг, нийслэлийн ЗДТГазруудын 2017 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь оноогоор адилхан (4.3 оноо) үнэлэгдсэн. Үүнд:

1. Өмнөговь аймаг-88.3% буюу 4.4 оноо
2. Нийслэл-86.4% буюу 4.3 оноо
3. Дорнод аймаг-86.4% буюу 4.3 оноо
- 4. Дархан-Уул аймаг-85.6% буюу 4.3 оноо**
5. Орхон аймаг-85.6% буюу 4.3 оноо.

Нэг. “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт”-ийн талаар:

2018 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Монгол Улсын 1 хуулийн 2 заалтын хэрэгжилт 30% буюу 1.5 оноо,
- УИХ-ын 2 тогтоолын 3 заалтын хэрэгжилт 66.6 % буюу 3.3 оноо,
- УИХ-ын байнгын хорооны 2 тогтоолын 3 заалтын хэрэгжилт 90.0% буюу 4.5 оноо,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 6 заалтын хэрэгжилт 66.66 % буюу 3.33 оноо,
- ҮАБЗ-ийн 2 зөвлөмжийн 3 заалтын хэрэгжилт 90.0% буюу 4.5 оноо,
- Засгийн газрын 41 тогтоолын 50 заалтын хэрэгжилт 74.80 % буюу 3.74 оноо,
- Ерөнхий Сайдын 1 захирамжийн 5 заалтын хэрэгжилт 68.0% буюу 3.4 оноо,
- Засгийн газрын хуралдааны 13 тэмдэглэлийн 20 заалтын хэрэгжилт 84.73 буюу 4.23 оноо,
- Засгийн газрын 1 албан даалгаврын 13 заалтын хэрэгжилт 83.33% буюу 4.16 онооны үнэлгээтэй байна.

№	Биелэлт	Нийт	Үүнээс								
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	68	1	2	2	5	2	41	1	13	1
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	105	2	3	3	6	3	50	5	20	13
3.	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	44	-	1	2	2	2	20	1	12	4
	Хэрэгжих шатанд 70%(50-89%)	39	-	1	1	2	1	21	3	5	5
	Хэрэгжилт хангалтгүй 30%(10-49%)	17	2	1	-	2	-	9	1	2	-
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	5	-	-	-	-	-	-	-	1	4
	Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь	76.40% буюу 3.82 оноо	30.0% буюу 1.5 оноо	66.66% буюу 3.33 оноо	90.0% буюу 4.5 оноо	66.6% буюу 3.33 оноо	90.0% буюу 4.5 оноо	74.80% буюу 3.74 оноо	68.0% буюу 3.4 оноо	84.73% буюу 4.23 оноо	83.33% буюу 4.16 оноо

Монгол Улсын хуулийн заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн нь онцлогтой байлаа.

- Ерөнхий чиг үүргийн салбарын асуудлын хүрээнд 10 шийдвэрийн 28 заалтын хэрэгжилт 83.33 % буюу 4.58 оноо,
- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын асуудлын хүрээнд 11 шийдвэрийн 15 заалтын хэрэгжилт 78.0 % буюу 3.9 оноо,

- Төлөвлөлт, санхүү хөрөнгө оруулалтын асуудлын хүрээнд 4 шийдвэрийн 6 заалтын хэрэгжилт 85.0% буюу 4.25 оноо,
- Хууль эрх зүйн салбарын асуудлын хүрээнд 8 шийдвэрийн 9 заалтын хэрэгжилт 71.11% буюу 3.55 оноо,
- Хүнс, хөдөө аж ауй, хөнгөн үйлдвэрийн салбарын асуудлын хүрээнд 9 шийдвэрийн 13 заалтын хэрэгжилт 76.92 % буюу 3.84 оноо,
- Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх салбарын асуудлын хүрээнд 5 шийдвэрийн 10 заалтын хэрэгжилт 71.25 буюу 3.56 оноо,
- Барилга, хот байгуулалтын салбарын асуудлын хүрээнд 5 шийдвэрийн 5 заалтын хэрэгжилт 54.0% буюу 2.7 оноо,
- Зам тээврийн салбарын асуудлын хүрээнд 2 шийдвэрийн 3 заалтын хэрэгжилт 30.0% буюу 1.5 оноо,
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын асуудлын хүрээнд 4 шийдвэрийн 4 заалтын хэрэгжилт 92.5% буюу 4.6 оноо,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын асуудлын хүрээнд 4 шийдвэрийн 5 заалтын хэрэгжилт 88.0 % буюу 4.4 оноо,
- Эрүүл мэндийн салбарын асуудлын хүрээнд 6 шийдвэрийн 7 заалтын хэрэгжилт 87.14 % буюу 4.35 онооны үзүүлэлттэй байна.

№	Биелэлт	Нийт	Зохицуулалтын салбар										
			Ерөнхий чиг үүрлийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Төлөвлөлт, санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ауйн хөнгөн үйлдвэр	Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх	Барилга хот байгуулалт	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	68	10	11	4	8	9	5	5	4	2	4	6
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	105	28	15	6	9	13	10	5	4	3	5	7
3.	Үүнээс Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	44	12	8	3	3	7	1	-	3	-	3	4
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	39	11	4	3	4	3	5	3	1	-	2	3
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	17	1	3	-	2	3	4	2	-	2	-	-
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	5	4	-	-	-	-	-	-	-	1	-	-
	Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь	76.40% буюу 3.82 оноо	83.33 буюу 4.58 оноо	78.0% буюу 3.9 оноо	85.0% буюу 4.25 оноо	71.11% буюу 3.55 оноо	76.92% буюу 3.84 оноо	71.25% буюу 3.56 оноо	54.0% буюу 2.7 оноо	92.5% буюу 4.62 оноо	30.0% буюу 1.5 оноо	88.0% буюу 4.4 оноо	87.14% буюу 4.35 оноо

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2018 оны эхний хагас жилийн байдлаар 68 шийдвэрийн 105 заалтаас 44 заалт 100 хувийн, 39 заалт нь 70 хувийн хэрэгжилтийн явцтай байна. Үүнээс дүгнэхэд 83 заалт буюу 79.0% нь харьцангуй сайн хэрэгжсэн байна.

Ерөнхий үнэлгээгээр **76.40** хувийн хэрэгжилттэй **3.82** онооны үнэлгээтэй байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

1. Цаашид бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, сүүлийн 3 жил тасарсан хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, өөрчлөлт оруулах тухай саналыг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-т уламжлах,
2. Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, хэрэгжилт тогтмолжсон, бүрэн биелсэн шийдвэрийн заалтыг хяналтнаас хасах тухай саналыг тайлангийн хамт бодлогын хэлтсээс ТЗУХ-т ирүүлэх,
3. **Албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх, тайланд арга хэмжээний явцыг бус үр дүнг тайлагнаж хэвших,**

4. Аймгийн ЗДТГ-ын даргын 2018.01.25-ны өдөр баталсан “2018 онд аймгийн ЗДТГ-т ирүүлэх болон дээд байгууллагат хүргүүлэх хугацаатай мэдээ, тайлангийн хуваарь”-ийн дагуу (Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт)-ийг бодлогын хэлтсүүд хугацаандаа Төрийн захиргааны удирдлагын хэлтэст, ТЗУХэлтэс нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст тус тус ирүүлж байх,
5. Аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд ажлын уялдаа холбоог сайжруулж байх, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах,
6. Салбарын тайланд дүгнэлт хийж удаашралтай, тасарсан заалтуудыг эрчимжүүлж ажилласан талаар хавсарган ирүүлж байх.

Хоёр. Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар:

2018 оны жилийн эхний хагас жилийн байдлаар Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын 20 зорилтын 30 арга хэмжээ 53.21 % буюу 2.66 онооны,
- Нийгмийн бодлогын 12 зорилтын 16 арга хэмжээ 76.0 % буюу 3.80 онооны,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 18 зорилтын 31 арга хэмжээ 67.05% буюу 3.35 онооны,
- Засаглалын бодлогын 5 зорилтын 7 арга хэмжээ 70.0% буюу 3.5 онооны
- Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан 9 зорилтын 9 арга хэмжээ 44.28 % буюу 2.21 онооны үнэлгээтэй байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс				Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан	
			Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	Нийгмийн бодлого	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	Засаглалын бодлого		
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	64	20	12	18	5	9	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	93	30	16	31	7	9	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	11	3	6	1	1	-
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	29	9	6	8	5	1
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40.0%	36	14	3	12	1	6
		Үр дүнгүй буюу 0.0%	8	2	-	6	-	-
		Үнэлэх боломжгүй	9	2	1	4	-	2
Хэрэгжилтийн хувь, оноо		54.40% буюу 2.72 оноо	53.21% буюу 2.66 оноо	76.0% буюу 3.8 оноо	67.05% буюу 3.35 оноо	70.0% буюу 3.5 оноо	44.28% буюу 2.21 оноо	

- Хууль, эрх зүйн хэлтсийн хүрээнд 2 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 55.0% буюу 2.75 оноо,
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд 37 зорилтын 58 арга хэмжээний хэрэгжилт 46.66 % буюу 3.58 оноо,
- Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд 16 зорилтын 20 арга хэмжээний хэрэгжилт 71.66 % буюу 3.58 оноо,
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 70.0% буюу 3.5 оноо,

- Орон нутгийн өмчийн газрын хүрээнд 2 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 70.0% буюу 3.5 оноо,
- Захирагчийн албаны хүрээнд 5 зорилтын 7 арга хэмжээний хэрэгжилт 48.57 % буюу 2.42 оноо,
- Мэдээлэл, технологийн албаны хүрээнд 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 85.0% буюу 4.25 онооны үзүүлэлттэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлогын хүрээнд авч үзвэл нийгмийн болон засаглалын бодлогын хүрээний хэрэгжилт “тодорхой үр дүнд хүрсэн”, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, аймаг орон нутгийн талаар тусгайлан оруулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ бусад бодлогын хэрэгжилтээс харьцангуй бага, зөрүүтэй байгааг анхаарч, цаашид уялдаа холбоог хангаж, жигд түвшинд хангах бодлогыг баримтлах нь зүйтэй байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс						
			Хууль эрх зүйн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хэлтэс	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Орон нутгийн өмчийн газар	Захирагчийн алба	Мэдээлэл технологийн алба
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	64	2	37	16	1	2	5	1
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	93	2	58	20	1	3	7	2
3.	Үүнээс								
	Үр дүнтэй буюу 100.0%	11	-	4	6	-	-	-	1
	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	29	1	14	7	1	3	2	1
	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40.0%	36	1	25	5	-	-	5	-
	Үр дүнгүй буюу 0.0%	8	-	8	-	-	-	-	-
	Үнэлэх боломжгүй	9	-	7	2	-	-	-	-
Хэрэгжилтийн хувь, оноо		54.40% буюу 2.72 оноо	55.0% буюу 2.75 оноо	46.66% буюу 2.33 оноо	71.66% буюу 3.58 оноо	70.0% буюу 3.5 оноо	70.0% буюу 3.5 оноо	48.57% буюу 2.42 оноо	85.0% буюу 4.25 оноо

Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 93 арга хэмжээний 43.01% буюу 40 арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай гэж үзэж болохоор байгаа бөгөөд эдгээрийн бодит үр дүнгийн талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Олон нийтийн зүгээс хүлээлт ихтэй, үр дүн нь иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх ялангуяа иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, нийгмийн шударга ёсыг хангахтай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хэрэгжилт сайтай байгаа, тодорхой үр дүнг хүсэн хүлээсэн иргэдийн хүлээлт ихтэй байгаа байдлаар нь холбогдох арга хэмжээг дурдвал:

2.23.6 Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх (мах, буудай, гурил)

2.26.3 “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх (100 сая төгрөг),

2.39.7 Газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, хоршоонд техник, технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, төмс хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх (“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр- 83.5 сая төгрөг бага оврын техник)

3.1.3.3 Элэгний вирусын халдвар, элэгний хатуурлыг оношлох багаж, хэрэгслээр эмнэлгүүдийг үе шаттайгаар хангах(2017 онд-78.0 сая, 2018 онд 43.4 сая төгрөг),

3.2.6.2 Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлыг сайжруулах (Улсын төсөв 1.5 тэрбум, Өвсний үндэс-187.0 сая, БНСУ-ын сайн дурын Залуучуудын холбооны 20.9 сая),

3.3.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх (Нийт 6 хөтөлбөрт 117 иргэн хамрагдаж 196 байнгын ажлын байр 282 түр ажлын байр тус тус бий болж 449,3 сая төгрөг зарцуулсан),

4.1.1.1 Ногоон хөгжлийн төлөөх түншлэлийг өргөжүүлж, жишиг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх (“Жишиг хороолол-1,2,3,4,5” төсөл)

4.2.5.2 Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, усыг хэмнэлттэй зарцуулах хэвшлийг бий болгох (2017 он-Усны тоолууржуулалт-I байр),

5.2.2.1 Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх (цахим худалдан авалтыг 100 хувь хэрэгжүүлж байна),

6.7.5 Хүүхэд хөгжлийн ордонтой болох зэрэг арга хэмжээнүүд байна.

Бүрэн эрхийн хугацаанд хэрэгжилт нь удааширч байгаа, эсхүл заасан хугацаанд хэрэгжих боломжгүй болсон арга хэмжээний (жишээ нь: Боловсрол хотхон, Дархан хотын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор цахилгаан дамжуулах төв шугамыг тойрог схемд шилжүүлэх гэх мэт) шалтгаан, нөхцлийг олон нийтэд бодит байдалд үндэслэн тайлбарлан таниулах ажлыг тухай бүрд нь хийх шаардлагатай байна.

Олон нийтийн зүгээс харьцангуй хүлээлт ихтэй байгаа зорилт арга хэмжээний хэрэгжилтийг онцгой анхаарч хэрэгжилтийг тодорхой үр дүнд хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах; Үүнд:

Зорилт 2.48 Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх,

Зорилт 2.77 “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх,

Зорилт 3.2.2 “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цэцэрлэгт хамрагдах боломжийг бодитоор бүрдүүлэх,

Бүлэг 6.7 Аймаг, орон нутгийг талаар тусгайлан оруулсан арга хэмжээ зэрэг болно.

Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээгээр **54.40** хувийн хэрэгжилттэй **2.72** онооны үнэлгээтэй байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

1. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй уялдуулан тайлагнах,
2. Албан хаагчид баримт бичиг боловсруулж тайлагнахдаа судалгаа, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах ур чадвараа нэмэгдүүлэх, арга хэмжээний явцыг бус үр дүнг тайлагнаж хэвших,
3. Албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллуулах,
4. Тодорхой асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллах,

Гурав. Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд:

1. Зарцуулсан хөрөнгийн хэмжээг бүрэн гүйцэт тусгах,

2. Хөтөлбөрт тусгагдсан 8 бүлэг, 11 дэд бүлэг, 139 зорилт, 307 арга хэмжээг тодорхой хүснэгтээр жагсаалт хийж товъёоглох,
3. Зорилтот түвшин, бодит үр дүнг ерөнхий томъёолох биш товч, тодорхой тайлагнах,
4. Хэрэгжилтийг тайлагнахдаа тухайн хэрэгжүүлсэн ажил хэзээ, хаана зохион байгуулагдсан, ямар байгууллагууд оролцсон тухай мэдээллийг орхигдуулахгүй байх,
5. Гүйцэтгэлийн ажлын явцыг хэт нуршихгүй байх,
6. Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн ажлын бодит үр дүнг, санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнах,.

Дөрөв. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:

1. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Дархан-Уул аймгийн ажилгүйдлийн түвшин 2017 онд 6.6 хувьтай гарсан байна. Үзүүлэлтийг 100 хувиар үнэллээ. /НБХ, ХХҮГ/,
2. Хэрэглээний үнийн индекс зорилтот түвшинээсээ өндөр гарсан байхад 100 хувиар үнэлсэн байна. Энэ нь аймгаас шууд шалтгаалахгүй үзүүлэлт учраас 40 хувиар үнэлсэн./ НБХ/,
3. Малын тоон өсөлт 2017 онд зорилтот түвшиндээ хүрээгүй, мөн суурь оноосоо багассан биелэлттэй байхад “Бэлчээрийн даацтай уялдуулан зохицуулах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх сонирхлыг дэмжих зорилттой нийцэж байгаа тул гүйцэтгэлийг үндсэн суурь үзүүлэлттэй харьцуулж бүрэн хангасан үнэлгээ өгсөн болно” гэсэн тайлбартайгаар 100 хувиар үнэлсэн байв. Зорилтдоо хүрээгүй учраас тайлбарыг харгалзан 70 хувиар үнэлж байна. /ХОХБТХ, ХХААГ/,
4. Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлтөд аймгаас шалтгаалахгүй зарим зүйлс /хууль/ нөлөөлснийг үзэж 40 хувиар үнэлсэн. /ХЭЗХ/,
5. Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин зорилтот түвшийхээ талд нь ч хүрээгүй байгаа хэдий ч ирүүлсэн тайлбар, онц их хэмжээний хохиролтой хоёр хэргийг харгалзан үнэлэлтийг 70 болгон нэмэгдүүлж байна. /ХЭЗХ/,
6. Цаашид Үндэсний статистикийн хорооны мэдээнд үндэслэж тоон мэдээг өгдөг байх,
7. Зорилтот түвшиндээ хүргэхийн тулд бүх хэлтэс, агентлагууд холбогдох заалт тус бүрт анхаарч, удирдлага, зохион байгуулалтийн арга хэмжээг авч ажиллах,

Тав. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хүрээнд:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1-т заасан үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, дутуу байршуулсан зарим тайлан, мэдээлэл (сул орон тооны зар, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг зэргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа талаарх мэдээлэл гэх мэт)-ийг цахим хуудсанд байршуулах ажил хангалтгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хариуцсан албан тушаалтан хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Зургаа. Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд:

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах ажлыг бүх трөлийн үзлэг шинжилгээ хийх, урт хугацааны тогтвортой хяналт хийж, ажлын байрны орчин нөхцлийг дээшлүүлэх чиглэлээрх ажлыг төлөвлөн зохион байгуулах.

Мэргэшсэн, чадварлаг, тогтвортой төрийн албыг бүрдүүлэх зарчмыг баримтлан “Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаарх” зорилтыг байгууллагыг үнэлэх үнэлэх нэг үзүүлэлт төдий үзэж буй дутагдалдаа дүгнэлт хийж, төрийн байгууллагын зохистой хүний нөөцийг бүрдүүлэх үндсэн хөшүүрэг, хүчин зүйлс болгон ажиллахыг зөвлөж байна.

Долоо. Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хүрээнд:

2017 онд хэрэгжүүлэх 39 арга хэмжээнээс 14 нь зөвлөгөөн, сургалт зохион байгуулах арга хэмжээ байв. Хамгийн тулгамдсан асуудал болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлийн арга хэмжээнүүд дутмаг байна. Цаашид үндсэн чиглэлийг боловсруулах шатанд анхаарах шаардлагатай. Мөн арга хэмжээний хүрэх түвшинг илүү тодорхой томъёолох (өмнөх онтой харьцуулах болон тоо, хувь хэмжээ, заах), арга хэмжээний хэрэгжилтээс бий болох үр дүнд чиглүүлэх шаардлагатай.

Найм. Хариуцлага

Эрх зүйн үндэслэл

1. Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.1.3 *“ХШҮ-ний зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцор саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах”, 12.2.1 “...зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан”, 12.2.2 “өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй”,*
2. Засгийн газрын 2017 оны 01 дүгээр *“Албан даалгавар”,*
3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.03.15-ны өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлд: Санал *“Зөвлөмжөө зөв өгсөн байна. Цаашид зөвлөмжийг яаж оновчтой хэрэгжүүлэх вэ гэдгийг анхаарч ажиллаарай. Ингэснээр төрийн байгууллагуудын ажил сайжирна. Аймгийн Засаг даргад зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах талаар тэмдэглэлээр чиглэл өгч байна”*
4. *“Хариуцлагын жил болгох тухай” Засгийн газрын 2018 оны 32 дугаар тогтоол*

2018 оны жилийн эцсийн “Үр дүнгийн гэрээ”-г дүгнэхэд хариуцлага тооцож ажиллах үндэслэл болно.

